



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/32

Мандалговь

“Миний гэр бүлийн баяр хөөр”
сургалтыг зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 18 дугаар зүйлийн 18.2.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” 03 дугаар тогтоол, Монгол Улсын Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 4.3.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоол, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтнуудын гэр бүлүүдийн хамтын аялалын өнгөрсөн, одоо, ирээдүйн түүхээр аялах тэдэнд гэр бүлийн бодит байдал, орчин нөхцөлийн талаарх үзэл бодол, ойлголтыг нэмэгдүүлэх, гэр бүлээ урамшуулах, дэмжих, хамгаалахад тустай энгийн арга замуудыг ойлгуулах гэр бүлийн сургалтыг 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсугай.

2. “Байгууллагын ажилтнуудын гэр бүлүүдэд “Миний гэр бүлийн баяр хөөр” сургалтыг зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 191.100 (Нэг зуун ерэн нэгэн мянга нэг зуун) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг газрын нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Залуучуудын хөгжлийн төвийн сургалт хариуцсан ажилтан (Б.Гэрэлсүрэн)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Залуучуудын хөгжлийн төвийн сургалт хариуцсан ажилтан (Б.Гэрэлсүрэн)-д даалгасугай.

ДАРГА  Ц.АНЗОРИГ



481190052